



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ  
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

14251 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
II хороо, Чингисийн өргөн чөлөө 11  
Утас: 62263168, Факс: (976-11) 31-23-15  
И-мэйл: info@mrtd.gov.mn, <https://www.mrtd.gov.mn>

2016.10.06 № 38-07-068/04

Г Техникийн нөхцөл олгох тухай Г

“Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 5<sup>2</sup>, 10 дугаар зүйл, “Төмөр замын тээврийн тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.4.6 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.5.2 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг тус тус үндэслэн “УБТЗ” ХНН-ийн Улаанбаатар-2 өртөөнд Замын 2-р ангийн арчлалт засвар үйлчилгээ хийдэг “Нийслэл өргөө” ХХК-ийн хашаа хүрэх салбар төмөр замын дэвсгэр зургийг холбогдох баримт бичигийн хамт газар дээр нь шалгаж үзээд “ЕвроКонстракшн” ХХК-ийн хүсэлтийн дагуу тус зам доогуур барилгын сантехникийн инженерийн шугамууд гаргах боломжийг судлаад дараах дүгнэлтийг гаргав.

**ТОДОРХОЙЛОХ НЬ:**

Тус салбар төмөр замын 42-р үеийн харалдаа бохир усны /Ф-150мм/ шугам, 46/47-р үеийн харалдаа дулааны хос /ф-100мм/, бохирын шугамыг тус тус төмөр замтай хоёр өөр түвшинд огтлолцуулан гаргах боломжтой байна. Үүнд:

1. “УБТЗ” ХНН-ийн Улаанбаатар-2 өртөөн дэх “Нийслэл өргөө” ХХК-ийн хашаа хүрэх салбар төмөр зам нь “УБТЗ” ХНН-ийн Замын 2-р анги хариуцан арчилгаа үйлчилгээ хийдэг замд хамаарч, нэгдмэл зурагт тусгагдсан бөгөөд одоогоор сэлгээний хөдөлгөөнд түр хаалттай байгаа болно.

2. Салбар төмөр замын 42-р үеийн харалдаа замын далан, ул шороог сувлэх технологоор огтлолцуулна.

3. Салбар төмөр замын 46/47-р үеийн харалдаа инженерийн шугам огтлолцуулахдаа замыг хуулж, далан ул шороог сэтлэж, зураг төслөөр заасан гүнд инженерийн шугамын хамгаалалтын зориулалт бүхий лотоки-г байрлуулсны дараа эргүүлэн ул шороог булж нягтуулах шаардлагатай.

4. Замыг хуулах ажил болон буцааж ул шороог байгуулах, замын үеийг дахин угсарч балластжуулан цахилгаан чигжүүрээр чигжих, замын цариг, түвшинг тохируулах ажлыг эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

**Хувийг: “УБТЗ” ХНН-ийн Замын 2-р ангид**

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ЗАМЫН  
ХЯНАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН  
УЛСЫН БАЙЦААГЧ

С.МАЙДАР

